

АНДХХ

АЗИ, НОМХОН ДАЛАЙН ХУДАЛДААНЫ
ХЭЛЭЛЦЭР



ТОВЧ ТОЙМ: АНДХХ (АРТА) ГЭЖ ЮУ ВЭ?

Өмнө нь (1975-2005 онд) Бангкокийн хэлэлцээр гэдэг байсан Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээр (АНДХХ, Asia-Pacific Trade Agreement - АРТА) нь Ази, Номхон далайн бус нутгийн хөгжиж буй орнуудын хооронд байгуулсан бус нутгийн тарифын хөнгөлөлтийн худалдааны хэлэлцээр юм. АНДХХ нь бус нутгийн худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд тус дөхөм болох худалдааны либералчлалын харилцан ашигтай арга хэмжээг батлан хэрэгжүүлэх замаар эдийн засгийн хөгжлийг дэмжих зорилготой.

Бангкокийн хэлэлцээрт 2005 онд анх нэмэлт өөрчлөлт оруулахаас өмнө энэхүү Хэлэлцээр нь түүний Оролцогч Улсуудын хооронд барааны худалдааны тарифын буултын хүрээг өргөтгөх явдалд голлон анхаарч байсан юм. Энэхүү нэмэлт өөрчлөлтөөр Сайд нарын Зөвлөлийт байгуулж, Зөвлөл нь 2005 оноос хийсэн дөрвөн удаагийн хуралдаанаараа АНДХХ-ийн хэлэлцээний цар хүрээг тэлж, хэд хэдэн чухал үр дүнд хүрсэн: Гарал үүслийн дүрмийг шинэчилсэн; АНДХХ-ийн хүрээнд нийлүүлэх барааны гарал үүслийн гэрчилгээ олгох, гарал үүслийг шалгах үйл ажиллагааны журмын ерөнхий багцыг баталсан; мөн худалдааг хөнгөвчлөх тухай, хөрөнгө оруулалтыг дэмжих, хамгаалах, чөлөөтэй болгох тухай, үйлчилгээний худалдааг дэмжих, чөлөөтэй болгох тухай ерөнхий хэлэлцээрүүдэд гарын үсэг зурсан. Эдгээр нь АНДХХ-ийн хамрах хүрээг барааны худалдаанаас цааш мэдэгдэхүйц хэмжээгээр өргөжүүлсэн. Сайд нарын Зөвлөлийн сүүлийн хуралдаанаар АНДХХ-ийн ирээдүйн замын зураглалыг баталсан. Энэхүү замын зураглал нь АНДХХ-ийг ээрэг жагсаалтад суурисан хөнгөлөлттэй худалдааны хэлэлцээрээс сөрөг жагсаалтад сууриссан чөлөөт худалдааны хэлэлцээр болгох, ингэснээр илүү олон салбарыг хамруулах, цаашлаад аажмаар бус нутгийн иж бүрэн түншлэлийн хэлэлцээр болгох урьдчилсан төсөөлөл юм.

АНДХХ-ийн Оролцогч Улсууд гэгдэх одоогийн гишүүд нь Бангладеш, Хятад, Энэтхэг, Лаос, Монгол, Өмнөд Солонгос, Шри Ланка болно. Монгол Улс АНДХХ-т 2020 онд нэгдсэн орсон.

АНДХХ-ИЙН ГОЛ ҮЙЛ ЯВДЛУУД



2020 оны 9-р сар
Монгол Улс АНДХХ -д албан ёсоор нэгдэн орсон

Хөрөнгө оруулалт, үйлчилгээ, худалдааг хөнгөвчлөх
асуудлаарх Ажлын хэсгүүдбайгуулагдсан

2018 оны
3-р сар:



2018 оны
7-р сар:



2017 оны
1-р сар:

Сайд нарын Зөвлөлийн 4-р
хуралдаан, Бангкок, Таиланд



2009 оны
12-р сар:



Сайд нарын Зөвлөлийн 3-р
хуралдаан, Сөүл, БНСУ.



2005 оны
11-р сар:

Сайд нарын Зөвлөлийн
анхдугаар хуралдаан
БНХАУ-ын Бээжин хотноо
зохиогдсон. “Бангкокийн
хэлэлцээр”-ийг “Ази, Номхон
Далайн Худалдааны Хэлэлцээр
(АНДХХ)” болгон ёсчилсон.



2006 оны
9-р сар

Тарифын хэлэлцээний Гуравдугаар үе
шатны үр дүнг хэрэгжүүлсэн



2007 оны
10-р сар

Сайд нарын Зөвлөлийн 2-р
хуралдаан, Гоа, Энэтхэг

2001 оны
4-р сар

Хятад Улс албан ёсоор нэгдэн орсон.



1975 ОНЫ
7-Р САР

Бангкокийн хэлэлцээрт
гарын үсэг зурсан



1976 ОНЫ
6-Р САР

Тарифын хэлэлцээний Нэгдүгээр
үе шатны үр дүнг
хэрэгжүүлсэн




1990 ОНЫ
5-Р САР

Тарифын хэлэлцээний Хоёрдугаар
үе шатны үр дүнг
хэрэгжүүлсэн

АНДХХ БҮС НУТГИЙН ИНТЕГРАЦЧИЛЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ХЭРЭГСЭЛ БОЛОХ НЬ

АНДХХ нь эдийн засгийн иж бүрэн хамтын ажиллагааны үр нөлөө бүхий бүс нутгийн хэлэлцээр болох зорилготой. Хэдий тийм боловч 4-р үе шатны хэлэлцээ хүртэл АНДХХ нь зөвхөн барааны худалдааг зохицуулж байсан. Урт хугацаанд үргэлжилсэн хэлэлцээний дүнд 2017 онд хуралдсан Сайд нарын Зөвлөлийн хуралдаанаар Оролцогч Улсууд АНДХХ-ийн цар хүрээг уламжлал ёсоор тарифын буулт хийх явдлаас өргөсгөж, худалдааг хөнгөвчлөх, үйлчилгээний худалдаа, хөрөнгө оруулалт, тарифын бус арга хэмжээ гэх зэрэг асуудлыг нэмж хамруулахаар тохиролцсон.

АНДХХ-ийн ирээдүйн замын зураглал



АНДХХ-г цааш нь өргөжүүлж, эрчим хүч; шинжлэх ухаан, технологи, инновац; мэдээлэл солилцоо, гаалийн хамтын ажиллагаа, ил тод байдлыг улам нэмэгдүүлэх, чадварыг бэхжүүлэх г.м. бусад салбар, чиглэлээр заалт оруулах нь уг Хэлэлцээрийг өргөжүүлэн, гүнзгийрүүлэх бололцоог нээж өгөх юм. Оролцогч Улсууд хоорондын худалдааны хамтын ажиллагаа, интеграцчиллыг цогцоор нь гүнзгийрүүлэн хөгжүүлэх нь АНДХХ-г Ази, Номхон далайн эдийн засгийн иж бүрэн түншлэлийн хэлэлцээр болгох зорилгод хүрэхэд улам бүр дөхөмтэй байх болно.

АНДХХ-ИЙН ОНЦЛОГ ШИНЖҮҮД

АНДЭЗНК-ИЙН ГИШҮҮН ХӨГЖИЖ БҮЙ БҮХ УЛСАД НЭЭЛТТЭЙ

АНДХХ нь Зүүн болон Өмнөд Азийг хамарсан бүс нутгийн худалдааны хэлэлцээр бөгөөд бусад дэд бүсийн, тухайлбал, Төв Ази болон Номхон далайн орнууд нэгдэн ороход нээлттэй юм. Тиймээс, энэхүү Хэлэлцээр нь ялангуяа түүний зарим Оролцогч Улс томоохон хэмжээний эдийн засагтай тул Өмнөд-Өмнөдийн худалдаа, хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих ховор боломж олгож байгаа юм.

Ази, Номхон далайн бүсэд хэрэгжүүлж буй хамгийн урт хугацаатай, томоохон зах зээлтэй хэлэлцээр

АНДХХ нь түүнд 1975 онд гарын үсэг зурснаас хойш Ази, Номхон далайн бүс нутагт хамгийн урт хугацаагаар хүчин төгөлдөр үйлчилж буй хэлэлцээрүүдийн нэг юм. Энэхүү Хэлэлцээр нь 2.7 тэрбум хэрэглэгчтэй Хятад, Энэтхэг улсууд түүнд нэгдэн орсноор, мөн БНСУ зэрэг өөр бусад томоохон зах зээлээр дамжуулан тухайн бүс нутгийн худалдааг өргөжүүлэн хөгжүүлэх асар их нөөц боломжтой.

Гарал үүслийн энгийн бөгөөд нийтлэг дүрэмтэй, Буурай хөгжилтэй орнуудад олгодог хөнгөлөлттэй нөхцөлтэй

АНДХХ нь барааны гарал үүслийн гэрчилгээ олгох, гарал үүслийг шалгах үйл ажиллагааны ерөнхий журмыг баталсан Ази, Номхон далайн хөгжиж буй орнуудын хооронд байгуулсан анхны хязгаарлагдмал тооны оролцогчидтой тарифын хөнгөлөлтийн хэлэлцээр юм. Буурай хөгжилтэй орнуудын хувьд АНДХХ нь тухайн улсад нэмэгдэх өртөг 10 нэгж хувиар бага байж болох (буюу зохих гарал үүсэлгүй материалыг 10 нэгж хувиар нэмж ашиглах) уян хатан заалттай.

АНДХХ-ийн гарал үүслийн дүрэм:

Дараах шаардлагын аль нэгийг хангасан аливаа бүтээгдэхүүн тарифын

ХӨНГӨЛӨЛТ ЭДЭЛНЭ:			
Дүрэм 2	Дүрэм 3	Дүрэм 4	Дүрэм 3 (В)
Бүрэн гарал үүсэлтэй бараа	Бүрэн бус гарал үүсэлтэй бараа	Нийлмэл гарал үүслийн дүрэм	Тарифын зүйл өөрчлөгдх (ЗТӨ)*
АНДХХ-ийн улсад 100% үйлдвэрлэсэн буюу бүрэн гарал үүсэлтэй бараа	Импортын орцын өртөг 55% (буурай хөгжилтэй улсын хувьд 65%-тай тэнцүү буюу түннээс бага байж	АНДХХ-ийн улсын зохих гарал үүсэлтэй импортын орцын өртөг нийлэд 60% (буурай хөгжилтэй улсын хувьд 50%-тай тэнцүү буюу түннээс их байж	156 зүйл (УС-ийн 4 орны

Эх сурвалж: Бангкокийн хэлэлцээрийн Нэмэлт өөрчлөлтийн 2-р хавсралт ба АНДХХ-ийн Хоёр дахь Нэмэлт өөрчлөлт

*"Тарифын зүйл өөрчлөгдх (ЗТӨ)" эзэдийг АНДХХ-ийн Хоёр дахь Нэмэлт өөрчлөлтөөр нэмсэн.

АНДХХ-ийн Хоёр дахь Нэмэлт өөрчлөлтөөр Гарал үүслийн дүрмийн хамрах хүрээг өртгөгчөсөн. Заримдаа нэмэгдсэн өртгийн агууламжийн шалгуурыг хангах нь хүндрэлтэй байдаг тул тарифын зүйл өөрчлөгдх (ЗТӨ – тарифын ангилал зүйлийн түвшинд өөрчлөгдх) гэсэн өөр нэг шалгуур тусгагдсан. Тодорхой бүтээгдэхүүн (156 зүйл)-ий зохих гарал үүсэлгүй орц нь экспортлогч АНДХХ-ийн оронд хийгдсэн ажиллагааны үр дүнд тарифын зүйлийн түвшинд өөрчлөгдсөн бол зохих гарал үүсэлтэйд тооцогдоно. Хэрэв тэдгээр нь тарифын зүйл өөрчлөгдх энэ шалгуурыг хангахгүй бол нэмэгдсэн өртгийн шаардлагын ерөнхий дүрэм (Дүрэм 3, эсхүл Дүрэм 4)-ийг мөрдөнө. Хамрах хүрээг өргөтгөсөн нь гарч буй саад тогторыг багасгах, өртгийн шинэ сүлжээ бий болох явдлыг дэмжих, мөн тарифын бус арга хэмжээ (хязгаарлалт)-г үгүй болгох зорилготой ба ингэх нь Оролцогч Улсууд хоорондын худалдаа нэмэгдүүлэхэд тулхэц болох юм.

ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН МЕХАНИЗМУУД

АНДХХ нь дараах байгууллагуудаас бүрддэг: Сайд нарын Зөвлөл, Байнгын хороо, худалдааг хөнгөвчлөх, үйлчилгээний худалдаа, хөрөнгө оруулалт, гарал үүслийн асуудал* хариуцсан дөрвөн Ажлын хэсэг, мөн АНДХХ-ийн Нарийн бичгийн даргын газар (АНДХХ-ийн Ажлын алба).

Сайд нарын Зөвлөл

Сайд нарын Зөвлөл бол шийдвэр гаргах эрх бүхий дээд байгууллага юм. Зөвлөл нь хэлэлцээний хамрах

хүрээ, шинээр гишүүн элсүүлэх, хэлэлцээрийн хэрэгжилтийг зохион байгуулах гэх зэрэг асуудалд хяналт тавьж, бодлогын чиглэл өгдөг болно.

АНДХХ-ийн Нарийн бичгийн даргын газар (Ажлын алба)

АНДЭЗНК-ийн Худалдаа, хөрөнгө оруулалт, инновацийн хэлтэс нь АНДХХ-ийн нарийн бичгийн дарга нарын газрын үүргийг гүйцэтгэдэг. Энэ хэлтэс нь уг Хэлэлцээрийг гүнзгийрүүлэн хөгжүүлж, түүний хамрах хүрээг өргөжүүлэх ажилд дэм болох, хэлэлцээрийн хүрээнд хийгдэж буй үйл ажиллагааг дэмжиж ажилладаг юм. АНДЭЗНК нь Ази. Номхон далайн бус нутагт бус нутгийн хөгжлийг дэмжих НҮБ-ын нэг тулгуур багана гэдэг утгаараа Ази, Номхон далайн орнуудын эдийн засаг, нийгмийн бүх талын, тогтвортой хөгжлийг хангах зорилгоор өөрийн гишүүн Улсууд хоорондын хамтын ажиллагааг хөхүүлэн дэмжих

Сайд
нарын
Зөвлөл

Байнгын
хороо

Байнгын хороо

Байнгын хороо нь жилд дор хаяж нэг удаа хуралдаанын дамжуулан АНДХХ-ийн үйл ажиллагааг ерөнхийд нь удирдан зохицуулдаг. Энэ хороо нь дараах ажил үүргийг хийж гүйцэтгэдэг. Үүнд: АНДХХ-ийн хэрэгжилтийг хянан үзэх; зөвлөлдөх уулзалт зохион байгуулах; шаардлагатай үед зөвлөгөө өгөх, шийдвэр гаргах; АНДХХ-ийн зорилтууд болон заалтууд зохих ёсоор хэрэгжих нөхцөлийг хангахад шаардлагатай аливаа арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

Ажлын хэсгүүд

АНДХХ-
ийн
НБДГ

Гарал
үүсэл

Худалдааг
хөнгөвчлөх

Үйлчилгээний
худалдаа

Хөрөнгө
оруулалт

Ажлын хэсгүүд

Сайд нарын Зөвлөлийн 4-р хуралдаанаас гаргасан шийдвэр дагуу Худалдааг хөнгөвчлөх, Хөрөнгө оруулалт болон Үйлчилгээний худалдааны асуудал хариуцсан гурван ажлын хэсэг байгуулагдсан. Эдгээр Ажлын хэсгүүд нь Худалдааг хөнгөвчлөх тухай, Хөрөнгө оруулалтыг дэмжих, хамгаалах, чөлөөтэй болгох тухай, Үйлчилгээний худалдааг дэмжих, чөлөөтэй болгох тухай ерөнхий хэлэлцээрүүдийн хүрээний үүрэг, амлалт болон асуудлуудаар хэлэлцээ хийдэг болно.

* Гарал үүслийн асуудал хариуцсан Ажлын хэсэг нь Бангкокийн хэлэлцээр байгуулагдсан цагаас эхлэн ажиллаж байгаа болно.

АНДХХ-ИЙН ХҮРЭЭНД БАРАА ИМПОРТЛОХ, ЭКСПОРТЛОХТОЙ ХОЛБООТОЙГООР АВАХ АЛХМУУД

Импорт

1. Импортын бараа хөнгөлөлтөд хамрагдах эсэхийг АНДХХ-ийн Хавсралт I Монгол Улсын Үндсэн хөнгөлөлтийн жагсаалтаас үзнэ.

/Хэлэлцээртэй холбоотой мэдээллийг ГХЯ болон MYXAYT цахим хуудас дээр байршуулсан/

2. Тухайн бараа Хөнгөлөлтийн жагсаалтад тусгагдсан байх тохиолдолд АНДХХ-ийн хүрээний Бүтээгдэхүүний гэрчилгээ шаардлагатай болохыг экспортлогч талд мэдэгдэнэ.

3. Барааны бүрдүүлэлт хийхдээ АНДХХ-ийн хүрээнд хөнгөлөлт эдлэх бараа болохыг тусгана. Бүтээгдэхүүн нь АНДХХ-ийн Гарал үүслийн дүрмийн холбогдох

Экспорт

1. Экспортлох гэж буй бараа хөнгөлөлтөд хамрагдах эсэхийг АНДХХ-ийн бусад гишүүн орнуудын Үндсэн хөнгөлөлтийн жагсаалтаас үзнэ.

2. Тухайн бараа Хөнгөлөлтийн жагсаалтад тусгагдсан байх тохиолдолд холбогдох Бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээ авахаар MYXAYT-д хандана.

MYXAYT Танхим нь “Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхимиын тухай” хуулийн 6.2.3 заалтыг үндэслэн, “Монгол улсаас гарал үүсэлтэй экспортын барааны гарал үүсэл тодорхойлох, гарал үүслийн гэрчилгээ олгох журам”-ын хүрээнд экспортын барааны гарал үүслийн гэрчилгээг олгодог

Хөнгөлөлт эдлэх бүтээгдэхүүн нь АНДХХ-ийн Гарал үүслийн дүрэмд зааснаар экспортлогч Оролцогч улсад бүрэн үйлдвэрлэгдсэн, эсхүл боловсруулагдсан, эсхүл экспортлогч Оролцогч улсад бүрэн үйлдвэрлэгдээгүй, боловсруулагдаагүй бол АНДХХ-ийн 1.2 Хавсралт II-ийн 3 ба 4 дүгээр дүрмийн шалгуурыг хангасан байх ёстой.

Монгол Улсаас гарал үүсэлтэй экспортын барааны гарал үүсэл тодорхойлох, гарал үүслийн гэрчилгээ олгох журамд заасны дагуу гарал үүслийн гэрчилгээ авахыг хүссэн иргэн, хуулийн этгээд дараах бичиг баримтыг бүрдүүлэн MYXAYT-д авчирч өгнө.

- Гадаад худалдааны гэрээний хуулбар /бараа худалдах, худалдан авах/
- Өргөдөл /Form B/
- Үнийн нэхэмжлэх, Сав баглаа боодлын жагсаалт /Invoice, Packing list/
- Тухайн барааны орц найрлагыг тодорхойлсон бичиг, түүхий эд нь импортоор орж ирсэн бол импортын гаалийн мэдүүлгийн хуулбар
- Тухайн хуулийн этгээдийн хүчин төгөлдөр бүхий улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, иргэн бол иргэний үнэмлэхний хуулбар
- Шаардлагатай тохиолдолд холбогдох нэмэлт бичиг баримт.

Дээрх бичиг баримтыг бүрдүүлэн урьдчилан хүсэлтээ онлайнаар илгээсний дараа, MYXAYT-дээр бичиг баримттайгаа ирж гарал үүслийн гэрчилгээгээ авах боломжтой.

Дэлгэрэнгүй мэдээллийг: <https://www.mongolchamber.mn/p/331>

**АНДХХ нь худалдаа, хөрөнгө оруулалтын боломжуудыг
өргөсгөх замаар Ази, Номхон далайн бүх дэд бүсийг
хооронд нь холбох боломжтой**

Холбоо барих хаяг:

АНДХХ-гийн Нарийн бичгийн даргын газар
Худалдаа, хөрөнгө оруулалт, инновацийн хэлтэс
НҮБ-ын Ази, Номхон далайн бүсийн Эдийн засаг,
Нийгмийн комисс
Ражадамнерн Нокийн өргөн чөлөө,
Бангкок 10200, Таиланд

Утас: +66 2288 2573

Факс: +66 2288 1027

Имэйл: escap-apt@un.org

АНДХХ-гийн албан ёсны вэб хуудас:

<http://www.unescap.org/pta>

Гадаад харилцааны яам

**Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын
ажиллагааны газар**

Имэйл:dep07@mfa.gov.mn

Вэб хуудас:

www.mfa.gov.mn